



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 115/ЗТ2023/0026

Сайншанд сум

**Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах,
хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх
шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох
нарийвчилсан журам батлах тухай**

Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнийг ерөнхий шүүгч Б.Цэнд даргалж, шүүгч Б.Сийлэгмааг оролцуулан, нарийн бичгийн даргаар шүүгчийн туслах Э.Болорцэцэгийг байлцуулан хийж, “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журам”-ыг батлах тухай асуудлыг хэлэлцээд

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.2.5, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.2, 72 дугаар зүйл, 74 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэгт заасныг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хэрэг хуваарилах шүүгчдийн дарааллыг сугалаагаар тогтоох.

1.1 Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилах, хэрэг маргаан хянан шийдвэрлэх шүүгчийг сугалаагаар тогтоосон дарааллыг Захиргааны хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системд:

1/ Шүүгч Б.Сийлэгмаа

2/ Ерөнхий шүүгч Б.Цэнд гэсэн дарааллаар,

2. Шүүх бүрэлдэхүүн болон даргалагчийг томилох.

2.1 Хэргийг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүний дарааллыг сугалаагаар тогтоосон дарааллаар буюу

1/ Ерөнхий шүүгч Б.Цэнд

2/ Шүүгч Б.Сийлэгмаа гэсэн дарааллаар тус тус байршуулан, тойрог үүсгэж тогтоосугай.

2.2 Шүүх хуралдаан даргалагч нь шүүгч дангаар болон шүүх бүрэлдэхүүнээр хянан хэлэлцэх хэргийг тогтоолын 1.1-д заасан тойргийн дагуу хүлээн авч тухайн хэрэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан шүүгч байхаар тогтоосугай.

014100047

3. Хэрэг хуваарилах журам батлах.

3.1. Шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т заасныг баримтлан Нийт шүүгчийн чуулганы хуралдааны 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 05 дугаар тогтоол /түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 04 дүгээр тогтоол/-д нийцүүлэн “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журам”-ыг хавсралтаар баталсугай.

4. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-д заасныг баримтлан шүүх хуралдааны даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор тогтоосон дарааллын дагуу Захиргааны хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системээс хуваарилсныг ерөнхий шүүгчийн захирамжаар албажуулсугай.


5. Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол болон тогтоолын хавсралтаар батлагдсан журмын дагуу Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд холбогдох тохиргоо хийхийг мэдээлэл технологийн мэргэжилтэнд даалгасугай.

6. Энэхүү тогтоолын зохион байгуулалт болон биелэлтийг хангаж ажиллахыг ерөнхий шүүгчид даалгасугай.

7. Уг тогтоол батлагдсантай холбогдуулан тус шүүхийн Шүүгчдийн Зөвлөгөөний 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 115/ЗТ2023/0005 дугаар тогтоол, түүний хавсралт /журам/-ыг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөр дуусгавар болгон хүчингүй болсонд тооцож, энэхүү тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГАЛАГЧ, ЕРӨНХИЙ ШҮҮГЧ


ШҮҮГЧ



Б.ЦЭНД

Б.СИЙЛЭГМАА

Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн
анхан шатны шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний
2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн
115/ЗТ2023/0026 дугаар тогтоолын хавсралт



**“ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛ, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ,
ХУВААРИЛАХ БОЛОН ХЭРЭГ, МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ШҮҮГЧ, ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СУГАЛААГААР ТОМИЛОХ
НАРИЙВЧИЛСАН ЖУРАМ”**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, шүүгчид хуваарилах, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилохдоо Нийт шүүгчийн чуулганы хуралдааны 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 05 дугаар тогтоол /түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 04 дүгээр тогтоол/-д нийцүүлэн гаргасан энэхүү нарийвчилсан журмыг баримтална.

1.2. Шүүхийн тамгын газрын Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан даруйд захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд /цаашид “нэгдсэн систем” гэж товчлох/ оруулан хуваарилалт хийж, дардас даран хүлээн авсан бүртгэлийн дэвтэрт цаг, минутын дарааллаар бүртгэн, хуваарилагдсан шүүгчид, хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүгчид хүлээлгэн өгөх боломжгүй бол шүүгчийн туслахад гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

1.3. Шүүхийн тамгын газрын Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн нэгдсэн системээр хуваарилагдсан хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдийн хүсэлтээр хэвлэн өгч, энэ тохиолдолд баримтыг хэрэгт хавсаргана.

1.4. Шүүгчийн туслах нь нотлох баримт цуглуулах болон хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой бусад асуудлын талаар хэргийн оролцогч, түүний төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргасан хүсэлт, шүүхэд ирүүлсэн бүхий л нотлох баримтуудыг хүлээн авч, бүртгэн холбогдох шүүгчид гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

Хоёр. Шүүгчид хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилах аргыг сонгох.

2.1. Шүүхэд шинээр ирсэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, шүүхийн даалгавар зэргийг нэгдсэн системээс урьдчилан мэдэх боломжгүй, тойрог дотор санамсаргүй тохиолдлоор сонгох зарчмыг баримтлан ердийн журмаар хуваарилах аргыг ашиглан шүүгчид хуваарилна.

2.2. Шүүгч шинээр томилогдсон, сэлгэн ажилласан, шилжин томилогдсон тухай бүр шүүгчдийн нэрсийн дараалалд сугалаагаар оруулж, нэгдсэн системд байршуулна.

2.3. Шүүх нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт зэргийг хүлээн авахаас татгалзсан, буцаасан болон мөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2-т зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж, тогтоол нь давж заалдах шатны шүүхээс хүчингүй болсон зэргээр уг нэхэмжлэл дахин ирсэн тохиолдол тус бүрт түүнийг өмнө шийдсэн шүүгчид нэгдсэн системээс гараар хуваарилах аргыг сонгож хуваарилна.

2.4. Давж заалдах болон хяналтын шатны шүүхээс шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаан ирүүлсэн хэргийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1, 84.1.6 дугаар зүйлд заасан зарчимд болон мөн журмын 2.1-д заасан зарчимд тус тус нийцүүлэн тухайн хэргийг шийдсэн шүүгчээс бусад шүүгчид сугалаагаар хуваарилна. Харин сугалаагаар хуваарилах боломжгүй нөхцөл байдал үүсвэл тухайн хэргийг программд гараар хуваарилна.

2.5. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д зааснаар шүүгч өөрөө татгалзан гарсан, эсхүл тус хуулийн 86 дугаар зүйлийн 86.1-д зааснаар шүүх бүрэлдэхүүн буюу шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хангасан бол тухайн шүүгч дээр байгаа хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт зэргийг энэ журмын 2.1-д заасан зарчимд нийцүүлэн мөн сугалаагаар бусад шүүгчид шилжүүлэн хуваарилна.

2.6. Шүүх бүрэлдэхүүнийг татгалзсан тохиолдолд өөр шүүх бүрэлдэхүүнээр солих, хэргийг анхан шатны өөр захиргааны хэргийн шүүхэд хянан шийдвэрлүүлэхээр шилжүүлэх ажиллагааг Ерөнхий шүүгчийн захирамжийг үндэслэн шүүгчийн туслах хийж, нэгдсэн системд зохих өөрчлөлтийг бүртгэнэ.

2.7. Тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргасан, эсхүл бүх шүүгч уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуульд заасан үндэслэлээр дахин оролцох боломжгүй болсон тохиолдолд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.

2.8. Томилогдсон шүүгч шүүх бүрэлдэхүүнд оролцох боломжгүй болсон тохиолдолд шүүгчдийн зөвлөгөөнөөс урьдчилан тогтоосон журамд заасны дагуу өөр шүүгчийг шүүх бүрэлдэхүүнд томилно.

2.9. Адил шатны өөр шүүхийн шүүх бүрэлдэхүүнд томилолтоор ажиллах шүүгчийг томилохдоо зөвлөгөөний тогтоолын 2.1-д заасан дарааллаар сонгоно.

2.10. Өөр, өөр шүүгч хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй хэргүүдийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д зааснаар нэгтгэх тохиолдолд шүүх хамгийн сүүлд хүлээн авсан хэрэгт нэгтгэнэ.

2.11. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-д зааснаар хэргийг тусгаарласан тохиолдолд тусгаарлагдсан хэрэг бүрийг тухайн шүүгч өөрөө хянан шийдвэрлэнэ.

2.12. Давж заалдах буюу хяналтын журмаар гомдол гаргах хугацаа сэргээлгэх, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг тухайн шийдвэрийг гаргасан шүүгч шийдвэрлэнэ. Харин тухайн шүүгч чөлөөлөгдсөн, шилжсэн, сэлгэсэн болон ээлжийн амралттай байх тохиолдолд дээрх хүсэлтийг бусад шүүгчид журмын 2.1-д заасны дагуу хуваарилна.

2.13. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулахаар ирүүлсэн хүсэлтийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.2-т заасан зарчимд нийцүүлэн тухайн хэргийг өмнө нь шийдсэн шүүгчээс бусад шүүгчид журмын 2.1-д заасан зарчимд нийцүүлэн хуваарилна.

2.14. Энэхүү журмын хэрэгжилтэд Ерөнхий шүүгч хяналт тавих бөгөөд журмаар зохицуулсан ажиллагаатай холбогдуулан шаардлагатай гэж үзсэн аливаа асуудлыг шийдвэрлэнэ.

Гурав: Бусад

3.1. Шүүгч хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгааны улмаас түр эзгүй байх тохиолдолд түүний хянан шийдвэрлэж байгаа хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, хүсэлт, гомдлыг шилжүүлэх асуудлыг Шүүгчдийн зөвлөгөөнөөр тухай бүр хэлэлцэн шийдвэрлэж, шилжүүлэхдээ журмын 2.1-д заасны дагуу бусад шүүгчид хуваарилна.

3.2. Шүүгчид хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилахгүй байх нөхцөл бий болсон бол хугацааг шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэж шийдвэрлэх ба өмнө нь тухайн шүүгчид хуваарилагдсан байгаа хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт зэргийг журмын 2.1-д заасны дагуу бусад шүүгчид хуваарилна.

3.3. Шүүгч ээлжийн амралт эдлэх тохиолдолд түүнд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт зэргийг хуваарилах асуудлыг 7 хоногийн өмнө зогсоож, шүүгч ээлжийн амралтаа эдэлж дуусгаад ажилдаа орсон өдрөөс түүнд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт зэргийг хуваарилж эхэлнэ.

3.4. Шүүгчийг ээлжийн амралтаа эдлэх болсон тохиолдолд тухайн шүүгч дээр хянагдаж байгаа, хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт зэргийг хянан шийдвэрлэх хуульд заасан хугацаатай холбогдуулан өөр шүүгчид шилжүүлэх, эсэх асуудлыг тухайн үед Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор шийдвэрлэж, хэрэв шилжүүлж шийдвэрлэх тохиолдолд тэдгээрийг журмын 2.1-д заасны дагуу бусад шүүгчид хуваарилна.

3.5. Шүүгч ээлжийн амралтаа эдэлж дууссан болон хүндэтгэн үзэх бусад шалтгаан арилж, шүүгч ажилдаа эргэн ормогц түүний өмнө нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байсан хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт зэргийг бусад шүүгчийн ажлын ачааллын байдлыг харгалзан буцаан шилжүүлэх, эсэх асуудлыг Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор шийдвэрлэж, үүнтэй холбогдох тохиргоог нэгдсэн системд хийхийг мэдээлэл технологийн мэргэжилтэнд мэдэгдэж, хийлгэх.

3.6. Шүүгч нарын тоо нэмэгдэх, хасагдах болон хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилах явцад энэ журмаар зохицуулагдаагүй асуудлууд гарвал тухай бүрд нь шүүгчдийн ээлжит бус зөвлөгөөнийг зарлан хуралдуулж шийдвэрлэнэ.

3.7. Энэ журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Ерөнхий шүүгч, шүүгчийн гаргасан саналыг Шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.8. Мөн энэ журамд тусгайлан зохицуулаагүй бусад асуудлыг шүүгчдийн зөвлөгөөнөөр тухай бүр хэлэлцэн шийдвэрлэж болно.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ**

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 115/ЗТ2024/0004

Сайншанд сум

**Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолд
өөрчлөлт оруулах тухай**

Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнийг ерөнхий шүүгч Б.Цэнд даргалж, шүүгч Б.Сийлэгмааг оролцуулан, нарийн бичгийн даргаар шүүгчийн туслах Э.Болорцэцэгийг байлцуулан хийж, тус шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 115/ЗТ2023/0026 дугаартай тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд:

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.5, 19.2.7 дахь зүйл, Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 115/ЗТ2023/0026 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журам”-ын 3.6-д заасныг болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Шүүгчийн сэлгэн ажиллах өргөдлийг шийдвэрлэх тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн

ТОГТООХ нь:

1. Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 115/ЗТ2023/0026 дугаар тогтоолын 1 дэх заалтын “1.1 Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилах, хэрэг маргаан хянан шийдвэрлэх шүүгчийг сугалаагаар тогтоосон дарааллыг Захиргааны хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системд:

- 1/ Шүүгч Б.Сийлэгмаа
- 2/ Ерөнхий шүүгч Б.Цэнд
- 3/ Шүүгч С.Отгонтуяа гэсэн дарааллаар,” гэж,

2. Мөн тогтоолын 2 дахь заалтын “2.1 Хэргийг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүний дарааллыг сугалаагаар тогтоосон дарааллаар буюу

- 1/ Ерөнхий шүүгч Б.Цэнд
- 2/ Шүүгч Б.Сийлэгмаа
- 3/ Шүүгч С.Отгонтуяа гэсэн дарааллаар тус тус байршуулан, тойрог үүсгэж тогтоосугай.” гэж тус тус өөрчилсүгэй.

014190059

3. Тогтоолд оруулсан өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс системд оруулж, хэрэгжүүлсүгэй.

ДАРГАЛАГЧ, ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

ШҮҮГЧ



Б.ЦЭНД

Б.СИЙЛЭГМАА